



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 659

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны харьяа "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн албан ажлын хэрэгцээнд зориулан 187,300,000.00 (нэг зуун наян долоон сая гурван зуун мянган) төгрөгт багтаан 1 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн зохицуулагч С.Должинсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын дагуу худалдан авсан хөрөнгийг төрийн өмчид бүртгэх ажилд биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
659 дугаар тогтоолын хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХАРЬЯА "НОГООН НУУР
1008 АЙЛЫН ОРОН СУУЦ" ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 4000 cc хүртэл, V6, CVTCS	1	187,300,000.00	187,300,000.00
	Нийт дүн			187,300,000.00 (нэг зуун наян долоон сая гурван зуун мянган)